



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

2018

**ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ, ИЛРҮҮЛЭХ, ТАСЛАН ЗОГСООХ ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТ
/ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА/**

ХУУЛЬ ЗҮЙН
СУДАЛГААНЫ
ТӨВ

Судалгааг захиалагч:

Хууль зүй, дотоод хэргийн яам

Судалгааг хянасан:

С.Энхцэцэг

ХЗҮХ-ийн захирал

Судалгааг удирдсан:

Х.Эрдэм-Ундрах

ХЗҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
Хууль зүйн ухааны доктор

Судалгааг гүйцэтгэсэн:

У.Эрдэнэзаяа

ХЗҮХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан,
Төрийн удирдлагын магистр

М.Очирбат

ХЗҮХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

ХУУЛЬ ЗҮЙН ХҮРЭЭГЭЛЭН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭГЭЛЭН
hii.gov.mn

АГУУЛГА

Оршил	4
Судалгааны зорилго	5
Судалгааны хамрах хүрээ	5
1. ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ	6
2. ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ИЛРҮҮЛЭХ, ТАСЛАН ЗОГСООХТОЙ ХОЛБОГДСОН ХАРИЛЦААНЫ ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ	8
2.1. Монгол Улсын хууль, бодлогын баримт бичиг	8
2.2. Бусад эрх зүйн акт	13
3. ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ГАДААД ОРНЫ ТУРШЛАГА	17
3.1. Олон улсын эрх зүйн зохицуулалт	17
3.1.1. Хүний эрхийн түгээмэл тунхаглал	17
3.1.2. Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт	17
3.1.3. Цахим орон зай дахь хүний эрхийн тунхаглал	17
3.1.4. Европын холбооноос баримталж буй бодлого	18
ГАДААД ОРНЫ ТУРШЛАГА	19
3.2.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын туршлага	19
3.2.2. Итали улсын туршлага	21
4. ДҮГНЭЛТ, САНАЛ	24
Санал	26
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	28
Хавсралт 1. Судалгаанд холбогдох мэдээллийг хэсэгчлэн авав.	1-5

ОРШИЛ

Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн “Цахим орчин дахь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох эрх зүйн зохицуулалт” сэдэвт харьцуулсан судалгааны ажлын захиалгад үндэслэн энэхүү судалгааг ХЗҮХ-ийн судлаачид хийж гүйцэтгэлээ.

Мэдээллийн технологи хурдацтай хөгжихийн хэрээр цахим орчинд иргэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж, өөрийн байр сууриа илэрхийлэх, нөгөөтэйгүүр олон нийтийн цахим сувгаас мэдээлэл авах боломж улам бүр нэмэгдэх хандлагатай болсон.

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооноос гаргасан судалгаагаар Монгол Улсад 2016 оны байдлаар давхардсан тоогоор 2.512.100 интернэт хэрэглэгч байгаагаас 30 сүлжээний хэрэглэгч 90.97 хувийг эзэлж, нийт хэрэглэгчийн хамрах хүрээ 86.7 хувь нь Улаанбаатар хотод, 10.3 хувь нь аймагуудад, 2.9 хувь нь сумдад, интернэт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 59 аж ахуй нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байна.¹ Интернэт нь иргэдийн бараг өдөр тутмын хэрэглээ болж, интернэт хэрэгслийг мэдээллийн эх сурвалж болгон ашиглах, түүнчлэн олон нийтийн сүлжээ ашиглаж үзэл бодлоо илэрхийлэх, аливаа зүйлийг нийтлэх болсон. Дээрх судалгаанаас үзвэл хүмүүс уламжлалт мэдээллийн хэрэгсэл ашиглахаас илүүтэй олон нийтийн сүлжээг илүү өргөн ашиглаж өөрийн үзэл бодол, байр сууриа илэрхийлэх болсон. Тухайлбал, цахим хуудас, юүтубе, фэйсбүүк, твиттер ашиглаж үзэл бодол, санал сэтгэгдлээ /коммент/ бичдэг болсон. Энэ нь нэг талаас иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх хэдий ч нөгөө талаас худал мэдээлэл тараах, бусдын нэр хүндэд халдаж гүтгэх, доромжлох явдал гарснаар иргэдийн эрх зөрчигдөх явдал гарч байна. Иймд цахим орчин дахь энэ төрлийн зөрчил, хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь цаг үеийн хэрэгцээ, шаардлага болоод байна.

Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд мөнгө угаах, хүний наймаа, хар тамхины болон цахим гэмт хэрэг зэрэг шинэ төрлийн гэмт хэргийг таслан зогсоох урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь мөн л цаг үеийн нөхцөл байдал шаардаж байна гэж үзэх үндэслэлтэй юм.

Цахим орчин дахь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох эрх зүйн зохицуулалтын асуудлыг судлахдаа олон улсын гэрээ, конвенци, олон улсын туршлагыг жишээ болгон авч үзсэн болно.

¹Д.Сумъяацэрэн, “Монгол Улс дахь кибер гэмт хэргийн нөхцөл байдал, үйлдлийн арга, урьдчилан сэргийлэх асуудал”, 2017 онд хэвлэгдсэн эрдэм шинжилгээний өгүүллээс дам эшлэв.

Судалгааны зорилго

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангах чиглэлийн 5 дугаар зүйлийн 5.4.4-т “Мөнгө угаах, хүний наймаа, хар тамхины болон цахим гэмт хэрэг зэрэг шинэ төрлийн гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ” гэх зорилтын хүрээнд холбогдох судалгааг хийж гүйцэтгэхэд судалгааны зорилго оршино.

Цахим орчин дахь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох эрх зүйн зохицуулалтын талаар олон улсын хууль тогтоомж, үзэл баримтлал, чиг хандлагад Монгол Улсын холбогдох хууль, Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/ тогтоомжийг нийцүүлэх, боловсронгуй болгох, гадаад орнуудын эрх зүйн зохицуулалтын туршлагаас судалж холбогдох дүгнэлт, саналыг боловсруулсан.

Судалгааны хамрах хүрээ

Уг судалгааны хамрах хүрээг олон нийтийн цахим сүлжээг ашиглаж худал мэдээ, мэдээлэл тараах, бусдыг гүтгэх, доромжлох, нэр төр, алдар хүндэд сөргөөр нөлөөлөх асуудлаар хязгаарласан болно.

1. ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

Юуны өмнө цахим орчин дахь гэмт хэргийн тухай ойлголтыг авч үзэхээс өмнө Кибер гэмт хэргийн талаарх ойлголтыг товч авч үзэх нь зүйтэй юм.

Кибер /Cyber/ гэх нэршил нь кибернетик гэх үгтэй утга дүйх ба утгачилан тайлбарлавал нарийн тооцоолон бодох техник-технологийн туслалцаатайгаар мэдээлэл боловсруулан үйл ажиллагааг удирдах буюу залуур зүй /удирдахуй тогтолцоо/ гэж ойлгогдоно. Энэ утгаараа Европын холбооноос цахим орон зайг нийтэд нь кибер орчин гэж өргөн хүрээнд нэрлэж байхаар шийдвэр гаргаж хэрэгжүүлж байна.²

Кибер гэмт хэргийн үндсэн асуудал нь компьютерын мэдээлэл, сүлжээний эсрэг гэмт хэрэг хамаарч байна уу, эсвэл компьютерын мэдээлэл сүлжээний тусламжтай үйлдсэн гэмт хэрэг хамаарч байна уу гэдэгт төвлөрдөг.

Кибер гэмт хэргийн тухай конвенцыг боловсруулагчдын зүгээс дээрх хоёр шинжийг хамтатгасан байдлаар кибер гэмт хэргийг тодорхойлж³, түүнийг төрөлжүүлсэн байдаг. Үүнд:

- Компьютерын мэдээлэл, сүлжээний бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлын эсрэг гэмт хэрэг
- Тооцоолох төхөөрөмж ашиглаж үйлдэх гэмт хэрэг
- Интернет дэх зохистой агуулгын эсрэг гэмт хэрэг
- Интернет дэх оюуны өмчийн эсрэг гэмт хэрэг гэж дөрвөн төрөлд ангилсан.⁴

Цахим сүлжээ бий болж хөгжсөнөөр нийгмийн харилцааны шинэ орчин гэж хэлж болох цахим орчинг бий болгосон. Цахим орчинг тодорхойлсон бүх нийтэд хүлээн зөвшөөрсөн нэгдсэн тодорхойлолт байхгүй ч энэ талаарх ойлголт чухал байдаг. Цахим орчинг /Cyberspace/ интернет, харилцаа холбооны сүлжээ, компьютерын сүлжээ, процессор зэрэг мэдээллийн технологийн харилцан хамааралтай дэд бүтцийн сүлжээнээс бүрдэх дэлхий нийтийн орон зай гэж ойлгодог.⁵

Цахим орчин нь хүн төрөлхтний мэдлэг мэдээлэл харилцан солилцох хэрэгцээнээс үүдэлтэй харилцан холбогдсон компьютеруудын сүлжээ ба энэхүү сүлжээ нь дэлхий дахиныг холбосон байдаг.

² Б.Хишигтогтох, Л.Цогтбаяр, Д.Сумъяацэрэн, Цахим мэдээллийн орчинд үйлдэгдэх гэмт хэргийн мөрдөн шинжлэхүйн онол, арга зүйн үндэс, сурах бичиг, УБ., 2015.

³ Л.Галбаатар, Кибер гэмт хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх нь, гарын авлага, УБ., 2015.

⁴ Дэлгэрэнгүй мэдээллийг Кибер гэмт хэргийн тухай 2001 оны Будапештын конвенцоос харна уу.

⁵ Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хамтын ажиллагааны эрх зүйн орчин, Олон улсын эрх зүй Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хамтын ажиллагаа, ЭШХ, 69 дэх тал, УБ., 2016.

Үүний илрэл нь хүмүүс цахим сүлжээг /цахим хуудас, фэйсбүүк, твиттер, юутубе зэрэг/ мэдээлэл солилцох, дамжуулах, үзэл бодлоо зураг, дүрсээр илэрхийлэхээс гадна зурвас болон сэтгэгдэл бичих зэргээр бие биетэйгээ харилцах талбар болгож байна.

Олон нийтийн сүлжээг хүмүүс үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл солилцох хэрэгсэл болгон ашигладаг боловч бас үүгээр дамжуулан худал мэдээ тараах, бусдыг доромжлох, гүтгэх үйлдэл гарч буй нь манай улсад төдийгүй дэлхийн улсуудад тулгамдаж буй асуудал болоод байна.

Олон улсын жишгээс харахад олон нийтийн сүлжээг ашиглаж хүний нэр төр, алдар хүндэд халдах, гүтгэх, доромжлох үйлдлийг гэмт хэрэг “мөн”, “биш” гэх маргаан дагуулах болсноор, өөрийн улсын үнэт зүйл, онцлог байдалдаа тулгуурлаж уг харилцааг хууль тогтоомжоор зохицуулах болжээ.

Манай улсын хувьд зарим эрдэмтэн, судлаачид гэмт хэрэг биш, Иргэний хуулиар зохицуулах боломжтой гэж үзэж байхад нөгөө хэсэг нь худал мэдээ тараах, хүний нэр төр, алдар хүндэд халдах үйлдлийг гэмт хэрэг гэж үзэж Эрүүгийн хуулиар зохицуулах ёстой гэж үздэг.

Олон нийтийн цахим сүлжээ ашиглаж бусдын алдар хүндэд халдаж гүтгэх, доромжлох, худал мэдээ тараасан тохиолдолд цахим гэмт хэрэгт тооцож болно гэж зарим судлаачид үздэг. Тухайлбал, судлаач Л.Галбаатар, Кибер гэмт хэргийн тухай конвенцод зааснаас бусад цахим гэмт хэргийг “цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэг” гэж үзнэ⁶ гэсэн байр суурьтай байна.

Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөгөө эдлэхдээ үүгээрээ дамжуулж бусдыг гүтгэх, доромжлох нь бусдын эрх чөлөөг зөрчиж байгаа үйлдэл нь бодитой юм. Үүнийг хууль зүйн шинжлэх ухааны үүднээс тайлбарлах юм бол бүх гэмт хэрэгт дөрвөн шинж байж шийтгэдэг. Энэ хоёр гэмт хэрэгт хэлбэрийн өөрөөр хэлбэл гүтгэсэн, доромжилсон байх юм бол мөрдөн байцаалтын аргаар тогтоох ёстой. Гэмт хэрэгт тооцож буй үндэслэл нь тухайн хүний өөрийнх нь үйлдэл, сэдэл санаатай нь холбоотой байдаг.⁷

Иймд Цахим орчинд худал мэдээ, мэдээлэл тараах, бусдыг доромжлох, гүтгэх үйлдлийг иргэний буруу гэхээс илүүтэй гэмт хэргийн үндсэн шинж, сэдэл, учруулсан хор хөнөөлийг нарийвчлан тодорхойлж гэмт хэрэг гэж үзэж тусгайлсан хуулиар зохицуулахыг санал болгодог хэсэг байхад, нөгөө хэсэг нь үүнийг Үндсэн хууль, Иргэний хууль, журмаар зохицуулах, эсхүл хувь хүний өөрийнх нь соёлын хэмжүүр болгох, мэдээлэл хүлээн авах боловсрол олгох тал дээр илүүтэй анхаардаг байна.

⁶ Судлаач Л.Галбаатартай хийсэн ярилцлагаас.

⁷ Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний бүх зарчим цахим орчинд ч адил үйлчлэх ёстой, Өдрийн сонинны редиакцийн хэлэлцүүлэг, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, хуульч Б.Пүрэвням, 2015.

2. ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ИЛРҮҮЛЭХ, ТАСЛАН ЗОГСООХТОЙ ХОЛБОГДСОН ХАРИЛЦААНЫ ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

2.1. Монгол Улсын хууль, бодлогын баримт бичиг

Монгол Улс өнгөрсөн хугацаанд цахим орчин дахь гэмт хэрэгтэй тэмцэхтэй холбогдуулан хууль, эрх зүйн актуудыг баталж хэрэгжүүлж байгаа нь энэ төрлийн харилцааг зохицуулах эрх зүйн орчинг тодорхой хэмжээгээр бүрдүүлжээ гэж үзэх үндэслэлтэй.

Монгол Улсын Үндсэн хууль /1992 он/

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16 дахь хэсэгт “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй.” хэмээн бататгасан байдаг. Энэ нь цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх, аливаа зүйлийг нийтлэхэд ч мөн адил хамааралтай билээ.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлж, хэвлэн нийтлэх эрх чөлөөгөө эдлэх нэг орон зай нь цахим орчин, цахим харилцаа болж, улам бүр өргөжих хандлагатай болж байна.

Хувь хүний нууцын тухай хууль /1995 он/

Энэ хуулийн “хувь хүний нууцыг тогтоох, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэсэнд хуулийн гол зорилт нь оршиж байна. Уг хуулиар "Хувь хүний нууц" гэж Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн нууцалсан бөгөөд задруулбал тухайн хүний хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулж болзошгүй мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хэлнэ хэмээн хувь хүний нууцын тухай ойлголтыг тодорхойлжээ.

Энэхүү хуулийн Хувь хүний нууцын төрөл, хувь хүний нууцыг хамгаалах хоёрдугаар бүлэгт Хувь хүний нууцын төрөл гэсэн 4 дүгээр зүйлд 1/захидал харилцааны нууц; 2/эрүүл мэндийн нууц; 3/хөрөнгийн нууц; 4/гэр бүлийн нууц; 5/хуулиар тогтоосон бусад нууц гэх төрөлүүдийг ойлголтуудыг тусгаж, хувь хүний нууцыг задруулсан тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг хуульчилсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль /1997 он/

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд “цахим, цахим орчин, олон нийтийн цахим сүлжээ ашиглаж” гэх тодотголтой нэр томъёо ороогүй хэдий ч энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, үндсэн зарчим, үндсэн чиглэл, ажлын төрөл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохион байгуулалт, оролцогчдын эрх үүрэг гэх зэрэг онцлог талуудыг хуулинд тусгажээ.

Уг хуульд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх иргэдийн эрх, үүрэгт: бусдын нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохироохгүй, нийгмийн хэв журмыг гажуудуулахгүй байх, мөн хэвлэл, мэдээллийн хэрэгслийн хүлээх үүрэгт: хохирогчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр түүний нүүр царай, дуу хоолойг танигдахуйц байдлаар гаргах, хувийн байдалтай холбоотой мэдээллийг тараах, хохирогчийг буруутгасан мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг хийхийг хориглохоор заасан байна.

Иргэний хууль /2002 он/

Иргэний нэр төр, алдар хүндэд халдах, худал мэдээ, мэдээлэл тараах, хариуцлагатай холбоотой зүйл, заалтуудыг Иргэний хуулиар зохицуулсан байдаг. Тухайлбал: Иргэний хуульд Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах гэсэн 21 дүгээр зүйл, бусдын эрх, ...нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд гэм хор учруулсан тохиолдолд гэм хор учруулснаас хариуцлага хүлээх үндэслэл гэсэн 497 дугаар зүйл, 511 дүгээр зүйлээр эдийн бус гэм хорыг арилгах талаар тус тус заажээ.

Харин уг хуулийн “Гэм хорыг арилгах” гэсэн арван наймдугаар бүлгийн 228, 229 дугаар зүйлд гэм хорыг арилгах эрх үүрэг, хэмжээг тогтоожээ. Тус хуулийн 230 дугаар зүйлд эдийн бус гэм хорыг арилгах талаар заахдаа “эдийн бус гэм хорыг гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд мөнгөөр нөхөн төлүүлнэ” гэж заасан байна.

Дээр дурдсан эдийн бус буюу сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлүүлэх талаар хууль тогтоомжинд тодорхой зааж өгөөгүй байгаа нь уг зохицуулалтыг нэг мөр ойлгож шийдвэрлэхэд тодорхойгүй байдал үүсгэх магадлалтай юм.

Нөгөөтэйгүүр Эдийн бус хохиролд чухам яг юуг хамааруулан ойлгох талаар тодорхойлоогүй нь эдийн бус буюу сэтгэл санааны гэм хорын ойлголтын талаар маргаантай асуудлыг үүсгэж болзошгүй үр дагавар гаргаж болох байна.⁸

Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан эдийн бус гэм хороос гадна үүнээс үүдэлтэй хүний амь нас хохироосон, хүний эрүүл мэнд нь хохирсноос үүсэх сэтгэл санааны хохиролыг хэрхэн үнэлэх үнэлгээ, яаж тооцох талаар тодорхойгүй байна.

Зар сурталчилгааны тухай хууль /2002 он/

Уг хуулиар зар сурталчилгааг нийтэд түгээхдээ “мэдээлэх хэрэгсэл” буюу телевиз, радио, холбооны шугам сүлжээ, компьютерын сүлжээ, тусгай программ, хэвлэл болон бусад арга хэрэгслийг ашиглахаар хуульчилсан байна. Ингэхдээ бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон зар сурталчилгаа, хууль бус сурталчилгаа явуулахыг хоригложээ.

⁸ Ш.Үнэнтөгс, Гүтгэлэг, нэр төр гутаах асуудлын эрх зүйн зохицуулалт, Нээлттэй нийгэм форум, УБ., 2008.

Тухайлбал, Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон зар сурталчилгаанаас хамгаалах гэх 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Зар сурталчилгаа нь хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон... үйлдэл хийсэн бол иргэн, хуулийн этгээд хуульд заасан үндэслэл, журмын дагуу няцаалт хийлгэх, учирсан гэм хорыг арилгахыг шаардах эрхтэйгээр хуульчилсан. Түүнчлэн Зар сурталчилгаа, түүнд тавих ерөнхий шаардлага, хориглох зүйлийг хоёрдугаар бүлэгт Хууль бус зар сурталчилгаа гэсэн 7 дугаар зүйлийн 7.2.2-т “бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд харш сурталчилгаа, 7.4.2-т Монгол Улсын болон бусад улсын төрийн бэлгэ тэмдэг, түүхэн алдарт хүн, үндэсний мөнгөн тэмдэгт, шашин шүтлэгийг гутаан доромжилсон бол ёс суртахуунд үл нийцсэн, 7.4.5-д үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нийгмийн гарал, байдал, нас, хүйс, мэргэжил боловсрол, шашин шүтлэг, үзэл бодлыг гутаан доромжилсон үг хэллэг, харьцуулалт, дүрслэл зэргийг ашигласан бол, 7.4.6-д хүнлэг ёс, ёс суртахуун, Монгол хүний эрхэмлэн дээдэлдэг зан заншлын ёс горимыг зөрчсөн тохиолдолд зүй бус зар сурталчилгаанд тооцохоор заасан байна. Тус хуулийн 16.1.1.-т “эцэг, эх, асран хүмүүжүүлэгчийн нэр хүндийг бууруулах” явдлыг “зар сурталчилгаанд тавих тусгай шаардлага”-аар /гуравдугаар бүлэг/ хориглохын зэрэгцээ “зар сурталчилгаа захиалагч, бүтээгч, түгээгчийн эрх, үүрэг” гэсэн дөрөвдүгээр бүлэгт зар сурталчилгаа бүтээх, түгээхэд хувь хүн, хуулийн этгээдийн оролцоо /23 дугаар зүйл/-г Зар сурталчилгаанд хувь хүн, түүний нэр, алдар хүнд, амьдрал ахуй, эд хөрөнгө, уран бүтээлийг үзүүлэх, дүрслэх, хэлсэн үгнээс нь ишлэл татах болон бусад хэлбэрээр ашиглахдаа тухайн хүн, эсхүл өв залгамжлагч, эрх залгамжлагчийн зөвшөөрлийг урьдчилан авах /23.1./-аар хуульчилж өгсөн байна.

Сонгуулийн хууль /2015 он/

Сонгуулийн хуульд “гүтгэх”, “доромжлох”-той холбоотой дараахь онцлог заалтуудыг тусгасан байна.

- Сонгуулийн сурталчилгааны үйл ажиллагааны баталгаажуулах хэсэгт нэр дэвшигчийг гүтгэх, доромжлох, нэр төрийг нь гутаах, түүний хувийн болон захидал харилцааны нууцыг задруулахыг хориглосон.
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орон зай, мессеж ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт зохион байгуулах, бусдыг гүтгэн доромжлох, хуурамч мэдээлэл тараах;
- ...худал мэдээлэл нийтэд тараах зэрэг хууль бус арга хэрэглэж санал авах байрын ажилд хөндлөнгөөс оролцвол... хуулийн дагуу хариуцлага тооцохоор тус тус заасан байна.

Эрүүгийн хууль /2015 он/

2015 оны Эрүүгийн хуулийн “Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг” гэсэн 26 дугаар бүлэгт Цахим мэдээлэлд хууль бусаар халдах гэсэн 26.1 дүгээр зүйл, Цахим мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдах программ, техник хэрэгсэл бэлтгэх, борлуулах гэсэн 26.2 дугаар зүйл, Хор хөнөөлт программ хангамж бүтээх, ашиглах, тараах 26.3 дугаар зүйлүүдийг гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан байна. Түүнчлэн хувь хүний нууцад халдах /13.10 дугаар зүйл/, хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах /16.9 дүгээр зүйл/, залилах /17.3 дугаар зүйл/ гэмт хэрэг үйлдэхдээ цахим сүлжээ ашиглаж үйлдсэн бол хүндрүүлэх нөхцөл байдлаар хуульчилжээ.

Хүүхэд хамгааллын тухай хууль /2016 он/

2016 онд батлагдсан Хүүхэд хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйл буюу “хэвлэл, мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгаалал” гэсэн зүйлээр цахим орчин дахь гэмт хэрэгтэй тэмцэх харилцааг зохицуулж байна.

Зөрчлийн тухай хууль /2017 он/

Зөрчлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-иар гүтгэх гэдэгт хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан /6.21 дүгээр зүйл/ тохиолдолд зөрчилд тооцжээ.

Дээрх хууль батлагдсанаар хүний нэр төр, алдар хүндийн эсрэг үйлдлийг Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцдог байсан бол Зөрчлийн тухай хууль батлагдсанаар уг хэргийг зөрчилд тооцохоор болсон.


2017 оны 7 дугаар сараас хойш Зөрчлийн тухай хуулийн “гүтгэх” /6.21 дүгээр зүйл/ зөрчил буюу хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан 111 зөрчил бүртгэгдсэн ба үүнээс 91 тохиолдлыг хэрэгсэхгүй болгосон бол 20 тохиолдлыг зөрчилд тооцож /шийтгэврээр торгосон/ хариуцлага тооцсон байна. /Зураг 1-ийг үзнэ үү/.

Зураг 1. Зөрчлийн тухай хууль /6.21 дүгээр зүйл. Гүтгэх/ 2017.07.01-ээс⁹, /тоон утгаар/



Дээр дурдсанчлан “гүтгэх”, “доромжлох” үйлдлийг урьд нь 2002 оны Эрүүгийн хуулийн Доромжлох буюу “Бусдын нэр төр, алдар хүндийг олон нийтийн өмнө доромжилсон” /110 дугаар зүйл/, Гүтгэх буюу “Хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэг тараасан” /111 дүгээр зүйл/ гэсэн зүйлээр тус тус зохицуулж байсан. Энэхүү хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг буюу доромжлох, гүтгэх хэргийн тоон үзүүлэлтийг 2011-2016 оны байдлаар авч үзье. /Зураг 2-ыг үзнэ үү/.

Зураг 2. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 110, 111 дүгээр зүйлээр бүртгэгдсэн гэмт хэргийн бүртгэл, шийдвэрлэлт /2011-2016 он/¹⁰



⁹ Цагдаагийн ерөнхий газар, Мэдээлэл нэгтгэн боловсруулах газрын Статистикийн хэлтэс 2011-2016 онд Цагдаагийн байгууллагын мэдээллийн санд ЭХТА-ийн 110, 111 дүгээр зүйл ангиар бүртгэгдсэн гэмт хэрэг, түүний шийдвэрлэлтийн статистик, судлаачийн эмхэтгэсэнээр.

¹⁰ Мөн тэнд.

Энэхүү тоон үзүүлэлтээс харвал 2011-2016 оны хооронд “доромжлох” гэмт хэрэг нийтдээ 74 бүртгэгдсэн ба нэг жилд дунджаар 12.3 орчим гэмт хэрэг бүртгэгддэг байна. Үүний 6-7 орчим хэргийг хэрэгсэхгүй болгох саналтайгаар прокурорт шилжүүлсэн бол 5-6 орчим хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэх саналтайгаар прокурорт шилжүүлсэн байна.

Гүтгэх хэрэг нийтдээ 144 бүртгэгдсэн ба дунджаар 12 орчим хэргийг хэрэгсэхгүй болгох саналтайгаар прокурорт шилжүүлсэн бол 11 орчим хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэх саналтайгаар прокурорт шилжүүлжээ.

Гэтэл Зөрчлийн тухай хуулийг мөрдөж эхэлснээс хойш хагас жил хүрэхгүй хугацаанд “гүтгэх” зөрчил 111 бүртгэгдсэн нь энэ хугацаанд дунджаар 22 зөрчил бүртгэгдсэн байгаа нь анхаарал татаж байна. Үүнээс 18 хувь нь шийтгэврээр торгож, 82.0 хувь нь хэрэгсэхгүй болсон байна/.

Дээрх байдалд олон хүчин зүйл нөлөөлж байгаагаас уламжлалт гүтгэх, доромжлох гэмт хэргээс ялгаатай “... худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан” гэсэн шинэ зохицуулалт, интернэт хэрэглэгч, интернэтийн үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагын тоо нэмэгдэж байгаатай холбоотой байж болох талтай юм.

2.2. Бусад эрх зүйн акт

Монгол Улсын Их Хурал 2010 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоолоор Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг баталсан.

Уг үзэл баримтлалд Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаандаа дараахь зарчмуудыг баримтласан байна. Үүнд:

- Эх оронч үндэсний үзлийг дээдлэх;
- Аюулгүй байдлын бодлого цогц байх;
- Мэдлэгт суурилах;
- Бодитой хандах;
- Даяаршлын хүчин зүйлийг харгалзах.

Аюулгүй байдлын бодлого цогц байх гэдэгт: Монгол Улсын “оршин тогтнохуйн аюулгүй байдал”, “эдийн засгийн аюулгүй байдал”, “дотоод аюулгүй байдал”, “хүний аюулгүй байдал”, “хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал”, “мэдээллийн аюулгүй байдал” харилцан уялдаатай хангагдсанаар үндэсний аюулгүй байдал баталгаажна.

Уг үзэл баримтлалын 3.6 дахь хэсэгт Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндсийг “Мэдээллийн салбарт үндэсний ашиг сонирхлыг хамгаалах, төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулах нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэс мөн.” хэмээн зааж өгсөн байна.

Уг үзэл баримтлалын 3.6.1.12.-т Мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийн орчинд сөргөлдөх аюулаас сэргийлэх, кибер орчин дахь гэмт явдалтай тэмцэх чиглэлд олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлнэ /3.6.1.12./ хэмээн тусгасан байна.

Засгийн газар 2016 оны 4 дүгээр сарын 11-ний 204 дүгээр тогтоолоор “Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө баталсан.

Уг төлөвлөгөөний наймдугаар хэсэгт: Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хангах чиглэлээр зөвлөмжид тусгаснаас гадна хэрэгжүүлэх арга хэмжээ, хугацаа болон гол үүрэг хүлээх субъектүүдийг тодорхой зааж өгсөн байна. Тухайлбал, интернэт орчинг оролцуулан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг бүх орчинд баталгаажуулах, нэр төр гутаах үйлдлийг эрүүгийн гэмт хэрэгт тооцохгүй байх..., нэр төр гутаах үйлдлийг эрүүгийн гэмт хэргээс хасах, олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцүүлэн Иргэний хуулийн журмаар шийдвэрлэх гэх зэргээр зөвлөмжид тодорхой тусгажээ. /дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс харна уу/.

Эрүүгийн хуулиас гүтгэх, доромжлох үйлдлийг хасч гэмт хэрэгт тооцохоо больсон нь Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт, НҮБ-ын хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжид нийцүүлсэн арга хэмжээний нэг нь болсон байна.

Монгол Улсын Засгийн Газраас 2013 оны 1 дүгээр сарын 5-ны 01 дүгээр тогтоолоор Цахим хуудас дахь сэтгэгдлийг зохистой хэрэглэх зорилгоор “Цахим хуудас дахь сэтгэгдлийн нэгдсэн систем”-ийн тухай журам баталсан.

Цахим хуудас дахь сэтгэгдлийн нэгдсэн системийг бий болгохдоо системийн программ хангамж, техникийн шийдлийг боловсруулан хэрэгжүүлэх арга хэмжээ авч, системийг тогтвортой ажиллуулах, ашиглах, домэйн нэр олголтыг зохион байгуулах болон мэдээ, мэдээллийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа цахим хуудсанд тавигдах шаардлагыг тодорхойлох, зохицуулах журмыг зохих хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж мөрдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төрийн холбогдох байгууллагуудад даалгасан.

“Цахим хуудас дахь сэтгэгдлийн нэгдсэн систем”-ийн мэдээллийн санг үүсгэх, ашиглахад шаардлагатай хуулийн этгээд болон иргэний бүртгэлтэй холбоотой мэдээллээр хангаж ажиллах, Цахим хуудас дахь сэтгэгдэлтэй холбоотой мэдээллийг системээс ашиглах, нягтлан шалгах программ хангамж, тоног төхөөрөмжийг тогтвортой, найдвартай ажиллуулах арга хэмжээ авах, сэтгэгдэлтэй холбоотой гомдол болон гүтгэн доромжилсон, садар самуунд уруу татсан, заналхийлсэн сэтгэгдлийг системээс нягтлан шалгаж тэдгээрийг бичсэн

этгээдийг тодруулж холбогдох хууль тогтоомжид заасны дагуу арга хэмжээ авах зэрэг ажлыг холбогдох байгууллагуудад үүрэг болгосон байна.

Үүний дагуу Харилцаа холбооны зохицуулах хорооноос 2013 оны 05 тоот тогтоолоор “Сайтууд дахь сэтгэгдлийн харилцааг зохицуулах журам”-ыг баталсан хэдий ч Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2014 оны ээлжит 7 дугаар хуралдаанаар “Сайтууд дахь сэтгэгдлийн харилцааг зохицуулах журам”-ыг хүчингүй болгох арга хэмжээг авсан байна.

“Сайтууд дахь сэтгэгдлийн харилцааг зохицуулах журам”-ыг хүчингүй болгох нь хэд хэдэн шалтгаантай байсан. Үүнд:

- Иргэд, олон нийт, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагын зүгээс “үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөнд” халдлаа, боомилох үндсийг тавьж байна хэмээн хүчтэй эсэргүүцэлтэй тулгарсан.
- Цахим эрх чөлөө ба нэрээ нууцлах эрх зөрчигдөж байна. Ялангуяа мэдээ, мэдээллийн цахим хуудсыг бүртгэж, шүүлтүүр хэрэглэж байгаа нь Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын 19 дүгээр зүйлтэй зөрчилдөж байна.¹¹
- Үзэл бодолтой байх, түүнийгээ илэрхийлэх эрх чөлөөнд тавих хязгаарлалтыг зөвхөн хуулиар тогтоох ёстой ч зохицуулах байгууллагын гаргасан, захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй, хүчин төгөлдөр бус дүрэм, журмаар хязгаарлалт тогтоож байгаа нь цензур болон ашиглагдаж байна¹² гэх зэрэг олон хүчин зүйл нөлөөлсөн байна.

Дээрх судалгаанаас харахад Монгол Улсад цахим орчин дахь худал мэдээ, мэдээлэл тараах, гүтгэх, доромжлох үйлдэл, түүнд хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг тодорхой байдлаар хуульчилсан байна гэж дүгнэж болох байна.

Гэхдээ хуулиудын уялдаа холбоо, хэрэгжилт тал дээр анхаарал хандуулж ажиллаа шаардлагатай байна. Нөгөөтэйгүүр юун түрүүнд цахим орчинд худал мэдээ, мэдээлэл тараах, бусдыг гүтгэж, доромжлох нь өөрөө хууль бус үйлдэл гэдгийг, нийгэм, хувь хүнд хичнээн их хор хөнөөл бий болдог, түүнээс учирч болох эрсдлийн талаар, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар иргэд, олон нийтэд хандсан уриалга сургалт, сурталчилгааг зохион байгуулах арга хэмжээ дутагдаж байна.

Түүнчлэн сүлжээг хаах боохоос илүүтэйгээр олон нийт рүү хандсан цахим орчинд мэдээлэл хүлээн авах, түгээхдээ хэрхэн зөв зохистой ашиглах, цаашид

¹¹ Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг, Глоб Интернэшнл ТББ, УБ., 2015.

¹² Мөн тэнд.

иргэд ёс зүйтэй байх хандлагыг төлөвшүүлэх, мөн цахим мэдээлэл хүлээн авах боловсролд нь илүүтэй анхаарч энэ чиглэлээр үйл ажиллагааг чиглүүлж зохион байгуулах ажилд зайлшгүй анхаарал хандуулах асуудал болж байна.

ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
nii.gov.mn

3. ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ГАДААД ОРНЫ ТУРШЛАГА

3.1. Олон улсын эрх зүйн зохицуулалт

3.1.1. Хүний эрхийн түгээмэл тунхаглал

Хүний эрх, эрх чөлөөтэй холбогдох олон улсын суурь баримт бичиг болох Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйлд, Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэхүү эрхэнд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрх чөлөө, үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана.

29 дүгээр зүйл 1. Хүн бүр нийгмийнхээ өмнө тодорхой үүрэг хүлээх бөгөөд гагцхүү нийгэм л бие хүний чөлөөтэй, өв тэгш хөгжлийг хангана.

2. Хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ гагцхүү бусдын эрх, эрх чөлөөг зохих ёсоор хүлээн зөвшөөрч хүндлэх, мөн ардчилсан нийгмийн ёс суртахууны шударга шаардлага, нийгмийн хэв журам, ерөнхий сайн сайхан байдлыг хангах үүднээс хуульчлан тогтоосноос өөр хязгаарлалтад өртөгдөх ёсгүй.

3. Эдгээр эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхдээ Нэгдсэн Үндэстний Байгууллагын зорилго, зарчимтай хэрхэвч зөрчилдүүлж болохгүй гэж заасан байдаг.

3.1.2. Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт

Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын 19 дүгээр зүйлд:

1. Хүн бүр үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрхтэй.
2. Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана гэж заасан байдаг.

Уг пактын 19.3-т зааснаар “Үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлаж болох боловч тэр нь заавал хуулиар тогтоогдсон байх ёстой бөгөөд дараахь шаардлагаас үүдэн гарах ёстой: 1-рт, бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх, 2-рт, Үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах үүднээс хязгаарлалтыг зөвхөн хуулийн дагуу хийж болно.

3.1.3. Цахим орон зай дахь хүний эрхийн тунхаглал

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын өөр нэг хувилбарыг Роберт Б.Гелман боловсруулсан.¹³ Уг төсөл нь Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг дэлхийн улс орнууд даяаршиж буй цахим орон зайд бэхжүүлэх үүднээс анхаарал

¹³ Л.Галбаатар, Цахим эрх зүй, ном, УБ., 2010.

хандуулсны илрэл юм. Цахим орон зай дахь хүний эрхийг тунхаглалын төслийг цахим орон зайг зохицуулах хэм хэмжээний зарчим жишиг гэж тооцогдож байна.

Цахим орон зайн хүний эрхийн түгээмэл тунхаглалын¹⁴ 5 дугаар зүйл. Хэн ч урьдчилсан зөвшөөрөл авалгүйгээр нийтэд хандсан хориглох их хэмжээний цахим шуудан, сервер компьютерт ачаалал үүсгэх хавсралт файл, хөнөөлт программ хангамж, бусад зүйлийг илгээх эрхгүй.

6 дугаар зүйл. Хүн бүр интернэтэд мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Энэхүү эрхээ эдлэхдээ тухайн харилцаанд тогтоосон зан үйлийн хэм хэмжээг сахин мөрдөнө.

7 дугаар зүйл. Цахим ба бодит орон зайд цөөнхийн болон хэрэглэгчийг тусгайлан хамгаална. Газарзүйн харьяаллын гэрээ ёсоор ял оногдуулах бол тэдний оршин байгаа эрх зүйн тогтолцооноос үл хамааран хувь хүний суурь эрхийг хүндэтгэнэ.

8 дугаар зүйл. Хүн бүр өөрийнх нь эрх, эрх чөлөө зөрчигдөх, хувийн мэдээллээ хортойгоор ашиглуулахын эсрэг хууль зүйн хамгаалалтад байх эрхтэй.

9 дүгээр зүйл. Хэнийг ч дур зоргоор хянаж, шалгахыг хориглоно.

13 дугаар зүйл. Хүн бүр өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй. Энэхүү эрх нь итгэл үнэмшил, сүсэг бишрэлээ төрөл бүрийн зан үйлээр илэрхийлэх эрхийг мөн агуулна. Хэний ч үзэл бодлоо илэрхийлсэн зан үйлийн хэлбэрт нь ял, зэмлэл хүлээлгэхийг хориглоно¹⁵.

15 дугаар зүйл. Хэний ч цахим шуудан болон бусад бүртгэлийг үйлчилгээний гэнэтийн өөрчлөлт гэх мэт зохисгүй шалтгаан, дур зоргоор хаах, устгахыг хориглоно гэж тус тус заажээ.

3.1.4. Европын холбооноос баримталж буй бодлого

Улс орон бүр худал мэдээ тараах, бусдыг гүтгэх, доромжлохын эсрэг тодорхой хууль, дүрэм, журам гаргахын урьдач нөхцөл нь ямар мэдээ, нийтлэлийг худал мэдээ, бусдыг гүтгэх, доромжлохыг зүй бус буюу хууль бус үйлдэл гэж, яагаад үүнийг сөрөг үзэгдэл хэмээн үзэж буй талаар нарийн тодорхойлох нь чухал юм.

“Үзэн ядсан яриа” /hate speech/ гэх ойлголтыг 2008 оны 9 дүгээр сарын 13-нд Европын холбооны Консулын ерөнхий шийдвэрийн дагуу гэмт хэргийн шинжтэй үйлдэл гэж үзэх болсон.

Уг шийдвэр нь “офлайн” болон “онлайн” ертөнцөд чухал ойлголт болж чадсан ба үндэсний эрх зүйн тогтолцоогоор гэмт хэрэгтнүүдийг “шийтгэх”

¹⁴ Л.Галбаатар, Цахим эрх зүй, ном, УБ., 2010, http://galbaatar.blogspot.com/2010/01/blog-post_31.html

¹⁵ <http://www.be-in.com/10/rightsdec.html>

боломжийг бий болгож өгсөн. Үүний үр дүнд Европын холбооны бодлогын ойрын зорилго нь үзэн ядсан яриаг хууль бус эсэхээр нь ангилж, тодорхой заасан хугацааны дотор хуурамч контентыг заавал арилгуулахаар зорьж байна.

Хуулийн тодорхой үзэл баримтлал, хуулийн хүрээ байх ба энэ нь хууль бус элементүүдийг /үзэн ядсан яриа, терроризмийг өдөөсөн, зохиогчийн эрхийг зөрчсөн гэх мэт/ агуулж байна гэж үзвэл, үүнийг тараасан хувь хүнийг болон онлайн мэдээллийн хэрэгслийг шүүхэд татаж болно гэжээ.

Харин хуурамч мэдээллийн эх сурвалж тодорхойгүй бол хэдий гэмт хэрэг байсан ч үүнийг нийтлэсэн зохиогчийг шүүхэд татах боломжгүй юм. Иймд хуурамч мэдээллийн хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэхийн тулд сэтгүүл зүйн чанарыг сайжруулах шаардлагатай байгаа зэрэг бодлогууд тусгагдсан байна.

Дээрх олон улсын эрх зүйн зохицуулалтаас харахад “нэг хүний эрх нөгөө хүний эрхээр хязгаарлагддаг” гэх зарчмыг баримталдаг байна. Энэ зарчим аливаа хэвлэн нийтлэл, үзэл бодлоо хэлэх эрхэд гагцхүү бусдын эрх, эрх чөлөөг зөрчсөн үйлдэл бодитой бол гэсэн ойлголт цахим орчинд ч мөн хамааралтай юм. Иймд хуулиар олон нийтийн цахим сүлжээ ашиглаж худал мэдээ тараах, бусдыг гүтгэх, доромжлох асуудлыг тодорхой хэмжээгээр хязгаарлаж болно. Гэхдээ уг эрхийг хязгаарлахад “цензур” тогтоох биш, гагцхүү хуулиар зохих хязгааралт тогтоож болно гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, хязгаарлалтыг үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүний нэр төр, алдар хүнд, амь нас, эрүүл мэндийг хамгаалах үүднээс худал мэдээ тараах /fake news/, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлаж болохыг дээрх пакт, тунхаглал, зөвлөмжид тусгасан байна. Гэхдээ энэхүү эрхийг хязгаарлахдаа заавал хуулиар тогтоогдсон байх зарчмыг баримтлах ёстой байна.

ГАДААД ОРНЫ ТУРШЛАГА

3.2.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын туршлага

Энэхүү цахим орчин дахь худал мэдээ тараах, доромжлох, гүтгэх үйлдлийг хэрхэн, яаж оновчтой зохицуулах нь /эрүүгийн, иргэний, захиргааны хуулиар уу, эсхүл журмаар уу/ мөн бусад улс орнуудын өмнө тулгараад байгаа асуудлын нэг болж байна.

Холбооны бүгд найрамдах Герман улс /Цаашид “ХБНГУ” гэх/ нь цахим орчны зохицуулалтын хүрээнд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхэд хүндэтгэлтэй хандахын зэрэгцээ эдгээр эрхийг тодорхой байдлаар хязгаарлах чиглэлээр тусгайлсан хуулиар зохицуулж байна. Уг харилцааг зохицуулж буй гол хууль болох “Нийгмийн сүлжээнд хуулийн хэрэгжилтийг сайжруулах тухай хууль /Сүлжээний хэрэгжилтийн тухай хууль/”, “Act to Improve Enforcement of the

Law in Social Networks /Network Enforcement Act”¹⁶-ийг 2017 оны 10 дугаар сараас мөрдөж эхэлсэн нь олон нийтийн цахим сүлжээнд хууль сахиулах шинэ алхам болж байна.

ХБНГУ¹⁷-ын 2016 оны 7, 8 дугаар сарын мэдээллээр ХБНГУ-д хэрэглэгчийн мэдэгдлээр хууль бус контентыг устгасан байдал Facebook-т 39-46 хувь, Youtube-д 10-90 хувь, Twitter-т 1 хувьтай байна. Энэ нь хэрэглэгчийн гомдлоор хууль бус контентыг устгах тал дээр олон нийтийн цахим сүлжээ ихэвчлэн “хойрго” ханддаг болохыг харуулсан байж болохоор байна. Үүнтэй холбоотойгоор ХБНГУ-д “Олон нийтийн цахим сүлжээнд хуулийн хэрэгжилтийг сайжруулах тухай хууль” үйлчилж эхлэв. Энэ хуулийн зохицуулалтыг багцлан хүргэж байна.

Хуулийн үйлчлэх хүрээ: Энэхүү хуулиар Facebook, YouTube, Twitter болон түүнтэй төстэй олон нийтийн цахим сүлжээн дэх хууль бус контент буюу үзэн ядсан үг хэллэг, гүтгэлэг болон хуурамч мэдээтэй тэмцэхийг зорьсон байна. Тодруулбал, хууль бус контент гэдэгт үзэн ядах /доромжлох, гүтгэх/ гэмт хэрэг, хуурамч мэдээлэл /гэмт хэргийн шинжтэй бол/, хүүхдийг садар самуунд ашигласан үйлдэл, терроризмыг сурталчлах агуулга хамаарна. Тус хуульд мэйл, цахим зурвасын үйлчилгээ хамаарахгүй. Олон нийтийн цахим сүлжээ бүр хууль сахиулах байгууллагын хүсэлтэд хариулах чиг үүрэг бүхий дотоодын төлөөлөгч ажиллуулах шаардлагыг хуульчилсан байна.

Хууль бус контентыг устгах: Тус хуулиар хэрэглэгчийн гомдлыг авсанаас хойш “илт хууль бус” контентыг 24 цагийн дотор олон нийтийн цахим сүлжээнээс устгах үүрэг хүлээлгэсэн. Хэрэв тухайн контент хууль бус эсэх нь илэрхий биш бол олон нийтийн цахим сүлжээнээс 7 хоногийн дотор хянан шалгаж, устгана. Хэрэв олон нийтийн цахим сүлжээнээс “Өөрийн зохицуулалт бүхий төлөөлөгч” гэж хүлээн зөвшөөрөгдсөн гадны төлөөлөгчийг хөлсөлж контентыг шалгуулж байгаа бол 7 хоногийн хугацааг сунгаж болно. Хууль бус контентыг тодорхойлохын тулд Эрүүгийн хуулийн холбогдох зүйл буюу хууль бус суртал ухуулгын материал тараах буюу Үндсэн хуульд харшилсан байгууллагын тэмдэглэгээг ашиглах; төрийн эсрэг онц хүнд гэмт хэрэг үйлдэхийг дэмжих; хууран мэхлэх гэмт хэрэг үйлдэхийг завдах; олон нийтийг гэмт хэрэгт уриалах; мөн үзэн ядахыг өөгшүүлэх болон бусад гэмт үйлдлийн зохицуулалтыг хэрэглэнэ. /Хууль бус контент гэдэгт ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 86, 86а, 89а, 91, 100а, 111, 126, 129 to 129b, 130, 131, 140, 166, 184b, 184d, 185 to, 187, 241, 269 дэх зүйлүүдийг илэрхийлсэн контентыг ойлгох талаар тус хуулийн 1 дэх хэсгийн 3-т заасан байна/.

¹⁶https://www.bmjv.de/SharedDocs/Gesetzgebungsverfahren/Dokumente/NetzDG_engl.pdf?__blob=publicationFile&v=2

¹⁷ Илүү тухтай, аюулгүй цахим орчин бүрдүүлэх нь, нийтлэлийн эмхэтгэл, УБ., 2017, 8 дахь тал.

Гомдол гаргах механизм ба хоёр жил тутмын тайлан: Олон нийтийн цахим сүлжээний үйлчилгээ үзүүлэгчдийн хувьд түүний хэрэглэгчид гомдол гаргахад хялбар, ил тод, байнгын механизм бий болгох үүрэгтэй. Мөн тухайн гомдлыг хүлээн авсан, татгалзсан зэрэг шийдвэрийг тухай бүр хэрэглэгчид мэдэгдэх ёстой. Мөн нэг жилийн хугацаанд хууль бус контентын тухай 100-аас дээш тооны гомдол хүлээн авдаг олон нийтийн цахим сүлжээнээс тухайн гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар хоёр жил тутам ХБНГУ-д тайлагнах шаардлагатай. Энэхүү тайлан нь Холбооны “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд болон олон нийтийн цахим сүлжээний зүгээс хууль бус үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээний мэдээлэл, гомдол барагдуулах журам, хүлээж авсан гомдлын тоо, гомдлыг хариуцаж буй ажилтнуудын мэргэжил, тоо, сүлжээний холбооны гишүүнчлэл, хууль бус контент эсэхийг шийдэхэд гуравдагч этгээдийг оролцуулсан тоо, гомдлын дагуу устгасан контентын тоо, контент устгахад зарцуулсан хугацаа, гомдол гаргагч болон устгасан контентыг нийтэлсэн гишүүнд мэдэгдэл хүргүүлсэн арга хэмжээ зэрэг мэдээллийг тусгана.

Торгууль: Дээр дурдсан үүргийг санаатай буюу болгоомжгүйгээр зөрчсөн олон нийтийн цахим сүлжээг торгоно. Хэрэв олон нийтийн цахим сүлжээнээс дотоодын төлөөлөгч ажиллуулаагүй буюу томилогдсон төлөөлөгч нь хүссэн мэдээллийг гаргаж өгөөгүй бол 5 сая хүртэлх еврогоор /ойролцоогоор 5.7 сая ам.доллар/ торгоно. Бусад бүх зөрчлийн хувьд, олон нийтийн цахим сүлжээг 50 сая хүртэлх еврогоор торгоно. Хэрэв устгах ёстой хууль бус контентыг устгаагүй гэж Хууль зүйн сайд үзэж, компанийг торгохыг хүсвэл энэ тухай шүүхээс шийдвэр гаргуулах ёстой.

3.2.2. Итали улсын туршлага

Цахим орчин дахь зохисгүй зан үйлийг хуулиар зохицуулах нь¹⁸: Итали улсад нэг жилийн хугацаанд цахим орчин дахь танхайрах үйлдэл, дарамттай холбоотой 7000 гаруй тусламж хүссэн гомдол хүлээн авч байна. Үүнтэй холбоотойгоор Итали Улсын парламентаас 2017 оны 05 дугаар сарын 17-ны өдөр “Цахим дарамтын эсрэг хууль” баталсан.

Хуулийн үйлчлэх хүрээ: Тус хуулийн зорилго нь цахим дарамт буюу цахим орчин дахь зүй бус үйлдлийг тогтоох, тийм үйлдлээс бусдыг, ялангуяа хүүхэд, өсвөр үеийнхнийг хамгаалах, тийнхүү хохирохоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулах, түүнчлэн цахим орчинд хүчирхийлэл үйлдэгчдийг дахин сурган хүмүүжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Тус хуульд “цахим орчин дахь зүй бус үйлдэл” гэдэгт “сэтгэл зүйн дарамт үзүүлэх, түрэмгийлэх, дарамт шахалт үзүүлэх, айлган сүрдүүлэх, гэмтээх,

¹⁸ Илүү тухтай, аюулгүй цахим орчин бүрдүүлэх нь, нийтлэлийн эмхэтгэл, УБ., 2017, 6 дахь тал.

доромжлох, нэр төрийг нь гутаах, гүтгэх, өөрчлөх, хувийн мэдээллийг нь залилан мэхэлж авах буюу ашиглах, өөрчлөх, насанд хүрээгүй хүмүүсийн хувийн мэдээллийг хууль бусаар боловсруулах, цахим хэрэгсэлээр дамжуулан түгээх, насанд хүрээгүй хүнийг бусдаас тусгаарлах, ганцаардуулахын тулд санаатайгаар буюу зориудаар үйлдэж буй ноцтой хүчирхийлэл, ноцтой халдлага, өргөн хүрээтэй, зохион байгуулалттайгаар үйлдэж буй зохисгүй зан үйл"-ийг ойлгоно гэж тодорхойлсон.

Цахим орчин дахь зүй бус үйлдийн талаарх гомдол гаргах, шийдвэрлэх нөхцөл: Цахим орчин дахь хүчирхийлэлд өртсөн 14-өөс доош насныхан болон тэдний эцэг эх нь өгөгдлийг хянагч буюу вэб сайтын үйлчилгээ үзүүлэгчтэй холбоо барьж хүчирхийлэл бүхий контентыг усгах, блоклох, хаахыг хүсэх, түүнчлэн нэн даруй устгуулах тухай хүсэлт гаргах боломжтой. Өгөгдөл хянагч нь 48 цагийн дотор хохирогчийг хамгаалах, цахим орчин дахь зохисгүй үйлдэл үргэлжлэхээс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай бүхий л алхамыг хийх үүрэгтэй. Хэрэв энэ үүргээ биелүүлэхгүй буюу зохих ёсоор биелүүлэхгүй бол хохирогч, түүний эцэг эхийн хувьд Өгөгдөл хамгаалах чиг үүрэг төрийн эрх бүхий байгууллагад шууд гомдол гаргаж болно. Өгөгдөл хамгаалах төрийн чиг үүрэг бүхий байгууллага нь тийнхүү гаргасан гомдлыг хүлээн авснаас хойш 48 цагийн дотор цахим дарамт, цахим орчин дахь зохисгүй үйлдэл бүхий контентод тусгай арга хэрэгслээр хөндлөнгөөс нөлөөлөх буюу тийм контентыг устгах, хаах эрх хэмжээтэй. Мөн цахим орчин дахь зүй бус үйлдэл гаргаж буй этгээдэд шийтгэл оногдуулах эрх хэмжээг Өгөгдөл хамгаалах чиг үүрэг бүхий төрийн эрх бүхий байгууллагад өгсөн.

Цахим орчин дахь үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг хариуцлага: Итали Улсын хувьд Европын холбооны гишүүн улсын хувьд Европын холбооны шийдвэрээр хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. Европын холбооны "Цахим худалдааны удирдамж" гэгдэх 31/2000/ЕС тоот удирдамж ёсоор "цахим орчин дахь үйлчилгээ үзүүлэгч" гэдэг нь олон нийтийн цахим сүлжээ, онлайн зурвасын платформ зэрэг цахим дарамт, цахим орчинд хүчирхийлэл үйлдэх боломжтой вэб сайтын зөвхөн контентыг зохицуулах үйлчилгээ үзүүлэгч юм. Энэ хүрээнд цахим орчин дахь үйлчилгээ үзүүлэгч нь Өгөгдөл хамгаалах чиг үүрэг бүхий төрийн эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах, харилцан туслалцах үүрэгтэй.

Гэмт хэрэг үйлдсэн хүмүүст илүү хатуу хариуцлага хүлээлгэх нь: Энэ хуульд Эрүүгийн хуульд заасан гэмт үйлдлийг цахим орчинд үйлдэх буюу цахим хэлбэрээр үйлдсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын хэмжээг Эрүүгийн хуульд зааснаас дордуулахгүй байх талаар заасан. Түүнчлэн, цахим орчинд 14 нас хүрээгүй хүн болон түүний гэр бүлийн эсрэг үйлдсэн нэр төр гутаах, заналхийлэх, хууль бус мэдээлэл боловсруулах гэмт хэрэгт ял шийтгэл

оногдуулна. Мөн цахим орчинд хүчирхийлэл үйлдэж буй насанд хүрээгүй этгээдийн үйлдэлд Эрүүгийн хууль бус энэ хуулиар хариуцлага хүлээлгэх боломжтой болсон.

Боловсролын сайд, сургуулиудын үндсэн үүрэг: Боловсролын асуудал эрхэлсэн төрийн эрх бүхий байгууллагаас цахим орчинд үйлдэх хүчирхийлэл, зүй бус үйлдлээс урьдчилан сэргийлэх удирдамж боловсруулах, батлах үүргийг тус хуулиар хүлээлгэсэн. Энэхүү удирдамжийг үндэсний болон орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх ёстой. Энэхүү удирдамжийн хүрээнд цахим орчин дахь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаарх бага хурал, семинар зохион байгуулах, нийтлэл гаргах зэрэг ажлыг хийх ёстой. Гэхдээ эдгээр ажлыг ямар сургууль, төрийн захиргааны байгууллага тухайлан хэрэгжүүлэх нь тодорхойгүй байна.

Энэхүү хуулийн хэрэгжилтийг хангах талаар Итали Улсын хууль тогтоогч анхаарчээ. Тодруулбал, хуулийн хэрэгжилтэнд мониторинг хийх, шинжээч, сонирхогч этгээдийг оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулах, Засгийн газраас цахим орчин дахь хүчирхийлэлтэй тэмцэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж байх нөхцөлийг хуульд тусгасан байна. Мөн цахим орчинд үйлдэгдэх гэмт хэргийн мэдээллийн сан бий болгох нөхцөлийг тус хуульд зохицуулжээ.

4. ДҮГНЭЛТ, САНАЛ

Мэдээлэл, технологи хурдацтай хөгжихийн зэрэгцээ “шинэ” харилцааг бий болгож байна. Үүний илрэл нь цахим мэдээлэл, харилцаа, орчин, орон зайг бий болгож байгаа явдал юм.

Монгол Улсын хувьд сүүлийн жилүүдэд олон нийтийн сүлжээ ашиглаж /цахим хуудас, фэйсбүүк, твиттер, ютубе зэрэг/ аливаа зүйлийг нийтлэх, үзэл бодлоо илэрхийлэх орон зай нэгэнт бүрдсэн. Энэхүү цахим харилцаанд оролцохдоо худал мэдээ, мэдээлэл тараах, бусдыг гүтгэх, доромжлох зүй бус үйлдэл гарах болсноор бусдын эрх чөлөөг хамгаалах шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Олон нийтийн сүлжээ ашиглаж худал мэдээ, мэдээлэл тараах, бусдыг гүтгэх, доромжлох, нэр төр, алдар хүндэд халдах хууль бус үйлдэл, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр өнгөрсөн хугацаанд эрх зүйн арга хэмжээ авагдсаны дотор Зөрчлийн тухай /шинэчилсэн найруулга/, Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/, Иргэний хууль /2002 он/, Хүүхэд хамгааллын тухай /2016/, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай /1997/, Сонгуулийн тухай /2015 он/¹⁹ зэрэг хуулиуд, Монгол Улсын Их Хурлын тогтоол “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, Засгийн газрын тогтоол “Цахим хуудас дахь сэтгэгдлийн нэгдсэн систем”-ийн тухай зэрэг бодлогын баримт бичгүүд батлагдан гарсан байна.

Эдгээр эрх зүйн актууд нь худал мэдээ тараах, бусдын нэр төрд халдаж гүтгэн доромжлох сөрөг үйлдлийг зохицуулах үндэс суурийг тавьсан гэж үзэх үндэстэй. Хэдий тийм боловч нэг талаар хууль тогтоомжийн хэрэгжилтэд анхаарах, нөгөө талаар цаг үеийн техник технологийн хурдтай өөрчлөлт, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан, түүнчлэн олон улсын жишиг, чиг хандлагатай нийцүүлэн “угтах бодлого”-ыг баримтлан үндэсний хууль, тогтоомжоо нийцүүлэн боловсруулах шаардлага тулгарч байна.

Олон нийтийн сүлжээ ашиглаж худал мэдээ, мэдээлэл тараах, бусдын нэр төрд халдаж гүтгэх, доромжлох зүй бус үйлдэл нь зөвхөн Монгол орноор хязгаарлагдахгүй дэлхийн улс орны хэмжээнд анхаарал хандуулсан асуудлын нэг болж байна.

Олон улсын хүрээнд авч үзвэл худал мэдээ, мэдээлэл тараах, бусдын нэр төрд халдаж гүтгэх, доромжлох үйлдлийг шууд “цахим орчин дахь гэмт хэрэг мөн, биш” гэдэг үзэл нь маргаантай байгаа хэдий ч хууль бус “буруу” зүйл гэдэг дээр санал нэгтэй байна. Энэ үүднээс уг асуудлыг хуулиар, дүрэм, журмаар

¹⁹ Эдгээр хуулиудад шууд болон шууд бусаар тусгагдсан байна.

эсхүл хувь хүний өөрийнх нь соёлын хэмжүүр болгох уу зэрэг хэрхэн, яаж зохицуулах вэ гэдэг асуудал гардаг байна.

Сүүлийн жилд Герман, Итали орнууд худал мэдээ, мэдээлэл тараах, бусдын нэр төр, алдар хүндийг гутаах үйлдлийг нилээд анхаарч хууль батлан хэрэгжүүлж байна. Уг хуулиуд нь батлан гаргахаас өмнө болон хэрэгжиж эхэлсэн ч маргаан дагуулсан хэвээр байна. Гол маргаан нь үзэл бодлоо илэрхийлэх эрхэд халдаж боомилж эхлэх үндэс тавигдлаа, хуулийг хэрэгжүүлэхэд асар их хэмжээний зардал шаардагдаж байна... гэх зэрэг байдлаас болж ялангуяа Герман улсад энэ байдал одоог хүртэл үргэлжилж уг хуулийг үргэлжлүүлэх эсэхийг зургаан сарын дараа шийдэхээр болж байна.

Ер нь цахим орчинд худал мэдээ, мэдээлэл тараах, бусдын нэр төр, алдар хүндийг гутаах үйлдлийг иргэний буруу гэхээс илүүтэй гэмт хэргийн үндсэн шинж, учруулсан хор хөнөөлийг нарийвчлан тодорхойлж гэмт хэрэг гэж үзэж тусгайлсан хуулиар зохицуулахыг санал болгодог хэсэг байхад, нөгөө хэсэг нь үүнийг Үндсэн хууль, Иргэний хууль, журмаар зохицуулах, эсхүл хувь хүний өөрийнх нь соёлын хэмжүүр болгох, мэдээлэл хүлээн авах боловсрол олгох тал дээр илүүтэй анхаардаг байна.

Иймээс цахим орчинд худал мэдээ, мэдээлэл тараах, бусдын нэр төр, алдар хүндийг гутаах үйлдлийг зохицуулахдаа үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, ашиг сонирхол, нөгөөтэйгүүр хүний нэр төр, алдар хүндэд халдсанаас үүсэх ноцтой хохирол, нийгэмд үзүүлж буй сөрөг нөлөө зэргийг харгалзан үзэж судалсны үндсэнд цахим орчин дахь гэмт хэрэг мөн эсэхийг тодруулж хуульчлах хандлагатай байна.

САНАЛ

1. Цахим орчинд худал мэдээ, мэдээлэл тараах, бусдыг гүтгэх, доромжлох үйлдлийг зохицуулахдаа олон нийтийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, ашиг сонирхол, нөгөөтэйгүүр хүний нэр төр, алдар хүндэд халдсанаас үүсэх ноцтой хохирол, нийгэмд үзүүлж буй сөрөг нөлөө зэргийг харгалзан үзэж судалсны үндсэнд цаашид хэрхэн яаж хуульчлахыг анхаарч үзэх хэрэгтэй юм.
2. Олон нийтийн сүлжээ ашиглаж хуурамч мэдээ, мэдээлэл тараах, бусдыг гүтгэх, доромжлох үйлдэлтэй тэмцэхдээ Үндсэн хууль /1992 он/, Иргэний хууль /2002 он/, Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/, Зөрчлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/..., Монгол Улсын Их Хурлын 2010 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, Засгийн газрын 2016 оны 4 дүгээр сарын 11-ний 204 дүгээр тогтоолоор “Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмж зэрэг бусад дотоодын хууль тогтоомжоос гадна Хүний эрхийн түгээмэл тунхаглал /1946 он/, Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт /1976 он/-ын 19 дүгээр зүйл, Цахим орон зай дахь хүний эрхийн тунхаглал /төсөл/, Европын холбооны зөвлөмжийг баримтлан үндэсний хууль тогтоомждоо нийцүүлж эрх зүйн орчинг боловсронгуй болгох боломжтой.
3. Зөрчлийн тухай хуульд 6.21 дүгээр зүйл /Гүтгэх/-д “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” хэмээн заасан. Уг зохицуулалт нь зөвхөн “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан” тохиолдолд хариуцлага хүлээхээр заасан байна. Эндээс практикт хүний нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг цахим сүлжээ ашиглаж олон нийтэд тараалгүйгээр хоёр субъектийн хоорондын үйлдэл болж, хэн нэг нь эрсдэлд орсон тохиолдолд хэрхэх талаар зохицуулалтыг бий болгох.
4. Интернэтийн зохицуулалтын хүрээнд хүний халдашгүй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарласан хуулийн зохицуулалт хийхдээ хардлагаас ангид байх үүднээс хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, интернэтийн үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгж, иргэдийг оролцуулах.

5. “Нэг хүний эрх нөгөө хүний эрхээр хязгаарлагддаг” гэх зарчим цахим орчинд ч мөн хамааралтай болж байна. Иймд олон нийтийн цахим сүлжээ ашиглаж худал мэдээ, мэдээлэл тараах, бусдыг гүтгэх, доромжлох үйлдлийг тодорхой байдлаар хязгаарлаж болно. Гэхдээ уг эрхийг хязгаарлахад “цензур” тогтоох биш, гагцхүү хуулиар зохих хязгаарлалтыг үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүний нэр төр, алдар хүнд, эрүүл мэнд, амь насыг хамгаалах үүднээс хязгаарлаж болно.
6. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай хууль шинээр батлах хэрэгцээ шаардлагыг судлахдаа уламжлалт сэтгүүл зүйг нийгмийн сүлжээнээс ялгаж үзэх нийгмийн шаардлага гарч байгааг харгалзан үзэж үүний зааг ялгааг тодорхойлж тодорхой байдлаар хуульчлах .
7. Олон нийт цахим орчин дахь мэдээллийг зохистой хэрэглэх мэдлэг дутмаг байгаа нь худал мэдээ тараах нэг үндэс нь болж байна. Үүнээс урьдчилан сэргийлэхийн тулд олон нийт рүү /зорилтот бүлэгт тохирсон/ хандсан олон нийтийн сүлжээг хэрхэн зөв, зохистой ашиглах тал дээр боловсрол олгоход анхаарч сургалт, мэдээ, мэдээлэл түгээх ажлыг эрчимжүүлэн зохион байгуулах. Өөрөөр хэлбэл цогц арга хэмжээ боловсруулж үйл ажиллагааг тогтмолжуулах шаардлагатай байна.
8. Цахим орчин дахь мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүднээс хяналт, шүүлтүүр тавьж хэрэгжүүлэх. Түүнчлэн олон хандалттай /2000-аас дээш/ цахим хуудас байвал түүнийг бүртгэдэг, мэдээллийг нь хянадаг, худал эсэхийг шүүдэг Хяналтын институт бий болгох хэрэгтэй байна. Одоогийн байдлаар энэ үйлдлийнхээ төлөө хэн ч хариуцлага хүлээхгүй, энэ үйлдэлд нь хариуцлага тооцох эзэнгүй учраас энэ байдал газар авч орхигдох хандлагатай байна.
9. Олон нийтийн сүлжээ ашиглаж үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй нь хамт үүрэг давхар бий болж байдаг. Өөрөөр хэлбэл эрх ба үүргийг тэнцвэржүүлэхэд анхаарах хэрэгтэй байна.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Нэг. Хууль, эрх зүйн акт

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, 1997.
3. Зар сурталчилгааны тухай хууль, 2002.
4. Зөрчлийн тухай хууль, 2017.
5. Иргэний хууль, 2002.
6. Сонгуулийн хууль, 2015.
7. Хүүхэд хамгааллын тухай хууль, 2016.
8. Эрүүгийн хууль, 2015.
9. “Цахим хуудас дахь сэтгэгдлийн нэгдсэн систем”-ийн тухай журам, Монгол Улсын Засгийн Газрын 01 дүгээр тогтоол, 2013.
10. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын Их Хурлын 48 дугаар тогтоол, 2010.
11. Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт, 1966.
12. Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1946.
13. Цахим орон зай дахь хүний эрхийн тунхаглал, 1996.

Хоёр. Ном, сурах бичиг

14. Л.Галбаатар, Кибер гэмт хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх нь, гарын авлага, УБ., 2015.
15. Л.Галбаатар, Цахим эрх зүй, ном, УБ., 2010.
16. Б.Хишигтогтох, Л.Цогтбаяр, Д.Сумъяацэрэн, Цахим мэдээллийн орчинд үйлдэгдэх гэмт хэргийн мөрдөн шинжлэхүйн онол, арга зүйн үндэс, сурах бичиг, УБ., 2015.

Гурав. Эрдэм шинжилгээний өгүүлэл

17. Д.Сумъяацэрэн, “Монгол Улс дахь кибер гэмт хэргийн нөхцөл байдал, үйлдлийн арга, урьдчилан сэргийлэх асуудал”, 2017.
18. Илүү тухтай, аюулгүй цахим орчин бүрдүүлэх нь, нийтлэлийн эмхэтгэл, УБ., 2017.
19. Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хамтын ажиллагааны эрх зүйн орчин, Олон улсын эрх зүй Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хамтын ажиллагаа, ЭШХ, УБ., 2016.
20. Ш.Үнэнтөгс, Гүтгэлэг, нэр төр гутаах асуудлын эрх зүйн зохицуулалт, Нээлттэй нийгэм форум, УБ., 2008.
21. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг, Глоб Интернэшнл ТББ, 2015.

Цахим эх сурвалж

22. http://galbaatar.blogspot.com/2010/01/blog-post_31.html

23. <http://www.be-in.com/10/rightsdec.html>

24. https://www.bmjv.de/SharedDocs/Gesetzgebungsverfahren/Dokumente/NetzDG_engl.pdf?__blob=publicationFile&v=2

Хууль зүйн
Нийслэл
Үндэсний Хүрээлэн
nii.gov.mn

Хавсралт 1. Судалгаанд холбогдох мэдээллийг хэсэгчлэн авав.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 4 дүгээр сарын 11-ний
өдөр

Улаанбаатар хот

Дугаар 204

ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Улсын Их Хурлын 2003 оны 41 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Ерөнхий төлөвлөгөөнд тусгасан эрхлэх асуудлын хүрээнд хамаарах арга хэмжээг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан зохион байгуулах, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг батлагдсан орон тоондоо багтаан тодорхой нэг албан хаагчид хариуцуулан тогтвортой ажиллуулах арга хэмжээ авч, төлөвлөгөөний биелэлтийн тайланг жил бүрийн 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор Хууль зүйн яаманд хүргүүлж байхыг холбогдох сайд, Засгийн газрын агентлаг, байгууллагын дарга нарт даалгаж, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Төрийн албаны зөвлөл, Сонгуулийн ерөнхий хороо, Хүний эрхийн Үндэстний комисст тус тус зөвлөсүгэй.

3. Дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хууль зүйн сайд Д.Дорлигжавт даалгасугай:

3.1. Хууль зүйн сайдаар ахлуулсан холбогдох яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагын дарга, ажилтан, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл бүхий ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй орон тооны бус зөвлөлийг байгуулж ажиллуулах;

3.2. Ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн 1 дүгээр сард багтаан энэ тогтоолын 3.1-д заасан орон тооны бус зөвлөлөөр хэлэлцүүлж, авах арга хэмжээний талаарх саналыг холбогдох тайлангийн хамт тухайн жилийн 2 дугаар сард багтаан Засгийн газарт танилцуулах;

3.3. Ерөнхий төлөвлөгөөний дунд хугацааны хэрэгжилтийн тайланг бэлтгэж 2018 оны 1 дүгээр сард багтаан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлд хүргүүлэх;

3.4. Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын талаарх үндэсний гуравдугаар илтгэлийг ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд тулгуурлан иргэний нийгмийн байгууллага болон холбогдох бусад байгууллагатай зөвшилцөн 2019 оны 9 дүгээр сард багтаан боловсруулж Засгийн газарт танилцуулах.

4. Ерөнхий төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг харьяа нутаг дэвсгэртээ зохион байгуулах арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, ерөнхий төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, зөвлөгөө өгч ажиллахыг Гадаад хэргийн сайд Л.Пүрэвсүрэнд тус тус үүрэг болгосугай.

5. Ерөнхий төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүр улс болон орон нутгийн төсвийн төсөлд тусган шийдвэрлүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Болор, холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгаж, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Төрийн албаны зөвлөл, Сонгуулийн ерөнхий хороо, Хүний эрхийн Үндэсний комисст тус тус зөвлөсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ч.САЙХАНБИЛЭГ

Гадаад хэргийн сайд

Л.ПҮРЭВСҮРЭН

ХУУЛЬ ЗҮЙН ЭГЭЛЭГ
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭ
nii.gov.mn

Хавсралт 1. Судалгаанд холбогдох мэдээллийг хэсэгчлэн авав.

Засгийн газрын 2016 оны 204 дүгээр тогтоолын хавсралт

**НҮБ-ЫН ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨВЛӨЛӨӨС ГАРГАСАН ЗӨВЛӨМЖҮҮДИЙГ 2016-2019 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Зөвлөмж/зөвлөмжийн дугаар	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага
Найм. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хангах чиглэлээр				
97	108.131. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн харилцааг зохицуулсан үндэсний хууль тогтоомжийг Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад нийцүүлэх, Харилцаа, холбооны зохицуулах хорооны хараат бус байдлыг хангах (Швейцар)	Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын 19 дүгээр зүйл, уг зүйлийн холбогдох тайлбартай үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг зохицуулсан үндэсний хүчин төгөлдөр хууль тогтоомж нийцэж байгаа эсэх талаарх судалгаа хийж, дүгнэлт гаргах, зөрчилтэй байгаа хууль тогтоомжийн шинэчилсэн төслүүдийг иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран зөвшилцөн боловсруулж, батлуулах, хэрэгжүүлэх	2016-2019	Хууль зүйн яам Харилцаа холбооны зохицуулах хороо Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар Иргэний нийгмийн байгууллага, салбар, мэргэшлийн холбоод
98	108.132. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн харилцааг зохицуулсан хууль, журмуудад Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактаар хүлээсэн Монгол Улсын үүрэгт бүрэн дүүрэн нийцүүлэх, нэр төр гутаахыг эрүүгийн гэмт хэрэгт тооцохгүй байх асуудлыг судлан үзэх (Америкийн Нэгдсэн Улс)	Харилцаа холбооны зохицуулах хорооны бие даасан байдлыг хангах зорилгоор Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах замаар Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга, хорооны гишүүдийн томилгоог Засгийн газраас хараат бус болгох		
99	108.133. Интернэт орчинг оролцуулан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг бүх орчинд баталгаажуулах (Франц)	Цахим хуудас дахь сэтгэгдлийн нэгдсэн системийн тухай Засгийн газрын 2013 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 1 дүгээр тогтоолыг хүчингүй болгох		
100	108.134. Интернэтийн зохицуулалтын бүх хүрээнд хүний халдашгүй байх болон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг оролцуулан хүний эрхэд бүрэн хүндэтгэлтэй хандах, эдгээр эрхийг аливаа байдлаар хязгаарлахдаа хуульд	Бүртгэл, шүүлтүүр хэрэглэх, тусгай зөвшөөрөл олгох зэрэг Харилцаа холбооны зохицуулах хорооноос батлан мөрдүүлж байгаа журам, стандартуудыг хянаж, нөлөөллийн үнэлгээ хийлгэх,		

	нийцсэн байх, зайлшгүй байх болон хязгаарлалтын хүрээ нь зөв тодорхойлогдсон байх зарчмыг баримтлах (Герман)	олон улсын хэм хэмжээ, жишгийн дагуу хуулиар зохицуулах · Гүтгэх, доромжлох үйлдлийг эрүүгийн гэмт хэрэгт тооцохоо болих асуудлыг судлан шийдвэрлэх · Эрүүгийн хуулийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд хязгаарлалт тогтоосон зүйл, заалтыг шүүмжлэлийг таслан зогсоох зорилгоор ашиглахгүй байх соёлыг бий болгох		
10	108.135. Сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн ажилтнууд болон иргэний нийгмийн зүтгэлтнүүд өөрсдийн үйл ажиллагааг олон улсын стандартад заасны дагуу шийтгэн цээрлүүлэх аливаа айдасгүйгээр чөлөөтэй эрхлэх бололцоог хангах (Эстони)	· Сэтгүүлчдийн мэдээллийн эх сурвалж болон шүгэлдэгчийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх · Төрийн албан хаагчдад, ялангуяа шүүх, прокурор, хууль сахиулах байгууллагын ажилтнуудад зориулсан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хувийн халдашгүй байдал, хэвлэл мэдээллийн эрх чөлөөний чиглэлээрх сургалтыг тогтмол явуулах		
102	108.136. Нэр төр гутаах үйлдлийг эрүүгийн гэмт хэрэгт тооцохгүй байх, төрийн болон орон нутгийн эрх бүхий байгууллагын үйл ажиллагааг сурвалжилсан, шүүмжилсний улмаас мөрдөн хавчигдах, эсхүл дарамт шахалтад орохоос хамгаалах орчинг бүрдүүлэх (Бүгд Найрамдах Чех Улс)	· Иргэдийн хувийн нууцыг хамгаалах, нэрээ нууцлах эрх, нууц нэр ашиглах эрхийг баталгаажуулах зорилгоор Хувь хүний нууцын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах		
103	108.137. Нэр төр гутаах үйлдлийг эрүүгийн гэмт хэргээс хасах, олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцүүлэн иргэний хуулийн журмаар шийдвэрлэх (Ирланд)	· Хэвлэл мэдээллийн бичиг үсгийн боловсролын талаар төрийн бодлого боловсруулж батлах, хэрэгжүүлэх · Сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн ажилтнууд, хүний эрхийг хамгаалагчид, иргэний нийгмийн зүтгэлтнүүд мэргэжлийн чиг үүрэг, үйл ажиллагаагаа айх айдасгүй, эрх зүйн таатай орчинд явуулах, үзэл бодлоо илэрхийлснийхээ төлөө аливаа дарамт шахалтад өртөхгүй байх эрх зүйн орчныг бүрдүүлэх, ийм төрлийн аливаа үйлдлийг мөрдөн шалгаж, гэм буруутанд		
104	108.138. Эрүүгийн хуулийн гүтгэх, доромжлохтой холбоотой зүйл, заалтын шүүмжлэлийг таслан зогсоох зорилгоор ашиглахгүй байх, сэтгүүлчдийн мэдээллийн эх сурвалж болон шүгэлдэгчийг хамгаалах (Австри)			

		ял шийтгэлийг хүлээлгэж хэвшүүлэх, мэргэшсэн хуульч өмгөөлөгчдийг бэлтгэх		
--	--	---	--	--

ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
nii.gov.mn